БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/95/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК
Захирал Г.Саранчимэг
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon @gmail.com
Аудитор: О.Мандах
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 11

4.АУДИТЫН ТАЙЛАН ........ 14

4.1 Ерөнхий зүйл ........ 14

4.2 Материаллаг байдал ........ 14

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 15

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

4.5.1 Завсрын аудитын талаар ........ 15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 16

5.1 Төлбөрийн акт ........ 16

5.2 Албан шаардлага ........ 17

5.3 Зөвлөмж ........ 17

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 18


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| НББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/30

танай___________-ны № ____________ -т

БӨМБӨГӨР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ж.ГАНТӨМӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 11 арга хэмжээний зардалд 1,353,684.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,175,845,8 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 4,973.4 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 177,491.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах,нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Аудитаар улирлын үр дүнгийн урамшууллын хувь буруу тооцсон, цахим дата хэрэглээний зардлыг журмын дагуу зарцуулаагүй,шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

5020139

зөрчил гарсан боловч илэрсэн зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг алдааны түвшнээс бага байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97,3 хувьтай тайлагнасныг 85.2 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **301,996,658.93** | **311,234,218.27** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **180,968,448.00** | **177,491,612.52** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **180,968,448.00** | **177,491,612.52** |
| **31210** | **Төгрөг** | **180,968,448.00** | **177,491,612.52** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 180,968,448.00 | 177,491,612.52 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **121,028,210.93** | **133,742,605.75** |
| **35100** | **Түүхий эд материал** | **72,965,852.97** | **72,988,654.67** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 72,717,852.97 | 72,988,654.67 |
| 35130 | Эм боох материал | 248,000.00 | 0 |
| **35400** | **Хангамжийн материал** | **48,062,357.96** | **60,753,951.08** |
| 35420 | Аж ахуйн материал | 29,292,637.24 | 42,935,227.24 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,456,000.00 | 0 |
| 35460 | Хүнсний материал | 31,780.00 | 0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,281,940.72 | 17,818,723.84 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,056,774,798.79** | **1,003,991,369.71** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,056,774,798.79** | **1,003,991,369.71** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,022,400,798.79** | **969,617,369.71** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 948,665,873.78 | 946,506,073.78 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -173,894,156.88 | -218,621,742.64 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 18,000,000.00 | 0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -12,000,000.00 | 0 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 252,527,494.45 | 245,219,329.43 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -108,249,846.44 | -100,987,070.91 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 124,516,038.26 | 129,151,447.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -63,423,742.64 | -67,909,805.57 |
| 39217 | Ном | 36,259,138.26 | 36,259,138.26 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **34,374,000.00** | **34,374,000.00** |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 34,374,000.00 | 34,374,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,358,771,457.72** | **1,315,225,587.98** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,358,771,457.72** | **1,315,225,587.98** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,358,771,457.72** | **1,315,225,587.98** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 433,663,308.00 | 433,663,308.00 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 433,663,308.00 | 433,663,308.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **436,681,968.30** | **393,136,098.56** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -922,139,489.42 | 436,681,968.30 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,358,821,457.72 | -43,545,869.74 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | 0 | 0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 488,426,181.42 | 488,426,181.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,358,771,457.72** | **1,315,225,587.98** |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
005

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,344,599,390.72** | **1,343,765,288.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **116,146,720.72** | **55,586,888.12** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **116,146,720.72** | **55,586,888.12** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,969,300.00** | **705,900.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,969,300.00 | 705,900.00 |
| 120009 | Бусад орлого | 130,000.00 | 140,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 108,624,780.00 | 17,971,205.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 5,422,640.72 | 36,769,783.12 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,228,452,670.00** | **1,288,178,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,079,550,100.00** | **1,171,523,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,079,550,100.00 | 1,171,523,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **48,562,170.00** | **0** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 48,562,170.00 | 0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **100,340,400.00** | **116,655,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 100,340,400.00 | 116,655,300.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,110,122,368.59** | **1,383,561,157.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,110,122,368.59** | **1,383,561,157.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **970,422,403.59** | **1,288,542,128.22** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **674,206,881.00** | **860,151,501.00** |
| 210101 | Үндсэн цалин | 459,575,152.00 | 597,118,760.00 |
| 210102 | Нэмэгдэл | 146,982,482.00 | 205,444,848.00 |
| 210104 | Урамшуулал | 30,634,452.00 | 57,587,893.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 37,014,795.00 | 0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **83,615,065.00** | **107,425,197.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 57,773,682.00 | 73,281,558.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,748,368.00 | 8,621,359.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,520,836.00 | 6,897,087.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,227,531.00 | 1,693,194.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,344,648.00 | 16,931,996.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **55,226,911.00** | **106,737,870.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,215,111.00 | 9,484,487.36 |
| 210302 | Түлш, халаалт | 47,516,000.00 | 96,010,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 495,800.00 | 1,242,583.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **22,648,050.00** | **35,611,408.30** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,008,950.00 | 4,284,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,512,600.00 | 860,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0 | 75,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 56,000.00 | 0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,626,000.00 | 6,317,400.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,444,500.00 | 24,074,608.30 |
| **2105** | **Нормативт зардал** | **16,139,552.00** | **26,160,260.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 806,250.00 | 160,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,333,302.00 | 26,000,260.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **9,009,500.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 9,009,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **799,000.00** | **0** |
| 210702 | Дотоод албан томилолт | 799,000.00 | 0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,955,300.00** | **8,360,607.48** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,969,300.00 | 705,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,986,000.00 | 7,654,707.48 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **106,831,644.59** | **135,085,784.08** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,359,700.00 | 24,428,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,492,450.00 | 9,750,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 83,979,494.59 | 100,907,384.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **139,699,965.00** | **95,019,029.64** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **139,635,470.00** | **90,045,600.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 59,922,000.00 | 60,192,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 48,562,170.00 | 0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 31,151,300.00 | 29,853,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **64,495.00** | **4,973,429.64** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 64,495.00 | 4,973,429.64 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **234,477,022.13** | **-39,795,869.74** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0** | **3,750,000.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 0 | 3,750,000.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **234,477,022.13** | **-43,545,869.74** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,230,421,970.00** | **1,289,024,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,969,300.00** | **845,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,969,300.00** | **845,900.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,969,300.00** | **845,900.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,969,300.00 | 705,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,228,452,670.00** | **1,288,178,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,079,550,100.00** | **1,171,523,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,079,550,100.00 | 1,171,523,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **48,562,170.00** | **0** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 48,562,170.00 | 0 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **100,340,400.00** | **116,655,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 100,340,400.00 | 116,655,300.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,027,537,102.00** | **1,258,598,385.48** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,027,537,102.00** | **1,258,598,385.48** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **887,837,137.00** | **1,163,579,355.84** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **670,874,653.00** | **860,151,501.00** |
| 210101 | Үндсэн цалин | 448,188,677.00 | 553,860,066.00 |
| 210102 | Нэмэгдэл | 154,263,344.00 | 251,063,811.00 |
| 210104 | Урамшуулал | 30,807,838.00 | 55,227,624.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 37,614,794.00 | 0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **86,997,293.00** | **107,425,197.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,080,386.16 | 73,281,558.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,374,987.11 | 8,621,351.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,699,929.70 | 6,897,087.82 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,258,352.48 | 1,693,194.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,583,637.55 | 16,932,004.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **56,158,911.00** | **103,281,870.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,553,176.00 | 9,244,645.36 |
| 210302 | Түлш, халаалт | 50,107,000.00 | 92,554,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 498,735.00 | 1,482,425.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **15,225,680.00** | **25,968,480.00** |
| 210502 | Хоол, хүнс | 15,225,680.00 | 25,968,480.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **8,400,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 8,400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,955,300.00** | **8,360,607.48** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,969,300.00 | 705,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,986,000.00 | 7,654,707.48 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **47,625,300.00** | **49,991,700.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,644,450.00 | 38,509,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,980,850.00 | 11,482,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **139,699,965.00** | **95,019,029.64** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **139,635,470.00** | **90,045,600.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 59,922,000.00 | 60,192,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 48,562,170.00 | 0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 31,151,300.00 | 29,853,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **64,495.00** | **4,973,429.64** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 64,495.00 | 4,973,429.64 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **202,884,868.00** | **30,425,914.52** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **21,916,420.00** | **33,902,750.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **21,916,420.00** | **33,902,750.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **21,916,420.00** | **33,902,750.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 21,916,420.00 | 33,902,750.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-21,916,420.00** | **-33,902,750.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **180,968,448.00** | **-3,476,835.48** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 180,968,448.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 180,968,448.00 | 177,491,612.52 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2022 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **202,204,946.17** | **1,124,294,435.59** |
| 2 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **202,204,946.17** | **1,124,294,435.59** |
| 3 | **Тайлант үеийн үр дүн** | **0** | **0** | **234,477,022.13** | **234,477,022.13** |
| 4 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **436,681,968.30** | **1,358,771,457.72** |
| 5 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **436,681,968.30** | **1,358,771,457.72** |
| 6 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **436,681,968.30** | **1,358,771,457.72** |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -43,545,869.74 | -43,545,869.74 |
| 8 | **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **433,663,308.00** | **488,426,181.42** | **393,136,098.56** | **1,315,225,587.98** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,470,339,600.0** | **1,287,527,705.8** | **182,811,894.2** | **87.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,470,339,600.0** | **1,287,527,705.8** | **182,811,894.2** | **87.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,365,357,400.0** | **1,197,482,105.8** | **167,875,294.2** | **87.7** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,003,184,400.0** | **860,151,501.0** | **143,032,899.0** | **85.7** |
| 210101 | Үндсэн цалин | 669,794,800.0 | 553,860,066.0 | 115,934,734.0 | 82.7 |
| 210102 | Нэмэгдэл | 271,652,500.0 | 251,063,811.0 | 20,588,689.0 | 92.4 |
| 210104 | Урамшуулал | 61,737,100.0 | 55,227,624.0 | 6,509,476.0 | 89.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **125,398,100.0** | **107,425,197.0** | **17,972,903.0** | **85.7** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 85,270,700.0 | 73,281,558.5 | 11,989,141.5 | 85.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,031,900.0 | 8,621,351.6 | 1,410,548.4 | 85.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,025,500.0 | 6,897,087.8 | 1,128,412.2 | 85.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,006,400.0 | 1,693,194.5 | 313,205.5 | 84.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,063,600.0 | 16,932,004.5 | 3,131,595.5 | 84.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **108,255,300.0** | **103,281,870.4** | **4,973,429.6** | **95.4** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,000,000.0 | 9,244,645.4 | 1,755,354.6 | 84.0 |
| 210302 | Түлш, халаалт | 95,755,300.0 | 92,554,800.0 | 3,200,500.0 | 96.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000.0 | 1,482,425.0 | 17,575.0 | 98.8 |
| **2105** | **Норматив зардал** | **27,349,400.0** | **25,968,480.0** | **1,380,920.0** | **95.0** |
| 210502 | Хоол, хүнс | 27,349,400.0 | 25,968,480.0 | 1,380,920.0 | 95.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,400,000.0** | **8,400,000.0** | **0.0** | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 8,400,000.0 | 8,400,000.0 | 0.0 | 100.0 |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,708,500.0** | **8,360,607.5** | **347,892.5** | **96.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,053,700.0 | 705,900.0 | 347,800.0 | 67.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,654,800.0 | 7,654,707.5 | 92.5 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **84,061,700.0** | **83,894,450.0** | **167,250.0** | **99.8** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 72,579,600.0 | 72,412,350.0 | 167,250.0 | 99.8 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,482,100.0 | 11,482,100.0 | 0.0 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **104,982,200.0** | **90,045,600.0** | **14,936,600.0** | **85.8** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **104,982,200.0** | **90,045,600.0** | **14,936,600.0** | **85.8** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 75,128,600.0 | 60,192,000.0 | 14,936,600.0 | 80.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 29,853,600.0 | 29,853,600.0 | 0.0 | 100.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,470,339,600.0** | **1,289,024,300.0** | **181,315,300.0** | **87.7** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,171,523,100.0** | **1,171,523,100.0** | **0.0** | 100.0 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,171,523,100.0 | 1,171,523,100.0 | 0.0 | 100.0 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **116,655,300.0** | **116,655,300.0** | **0.0** | 100.0 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 116,655,300.0 | 116,655,300.0 | 0.0 | 100.0 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **182,161,200.0** | **845,900.0** | **181,315,300.0** | **0.5** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,053,700.0 | 705,900.0 | 347,800.0 | 67.0 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 140,000.0 | 140,000.0 | 0.0 | 100.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 180,967,500.0 | 0.0 | 180,967,500.0 | 0.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 180,968,448.0 | **-180,968,448.0** | **0.0** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 177,491,612.5 | **-177,491,612.5** | **0.0** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **0.0** | **0.0** | **0.0** | **0.0** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.0** | **1.0** | **0.0** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.0 | 1.0 | 0.0 | **100.0** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **49.0** | **47.0** | **0.0** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 3.0 | 3.0 | 0.0 | **100.0** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 28.0 | 26.0 | 0.0 | **100.0** |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 18.0 | 18.0 | 0.0 | **100.0** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тодорхойлсон "Суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино" гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 47 орон тоотой, 472 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ж. Гантөмөр, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Ганболд нар зурж, нярваар Б.Эрдэнэ-Очир нар ажиллажээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Боловсрол,шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,545,8 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 180.968.4 | 177.491.6 | -3.476.8 |
| Авлага | 0 | - | 0 |
| Бараа материал | 121.028.2 | 133.742.6 | 12.714.3 |
| Үндсэн хөрөнгө | 1,414,792.5 | 1.391.959.9 | -22.832.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | -358,017.7 | -387,968.6 | -29,950,9 |
| **Нийт хөрөнгө** | **1.358.771.4** | **1.315.225.5** | -43.545.8 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **1.358.771.4** | **1.315.225.5** | -43.545.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1.358.771.4** | **1.315.225.5** | -43.545.8 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын сургуулийн санхүүгийн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгө 177,491.6 мянган төгрөг болж өмнөх оноос 3,476.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 192,867.3 мянга, 36,769.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй орлого авч үйл ажиллагаанд 192,848.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулж Сургуулийн захирлын 2023.10.26-ны өдрийн А/31, 2022.12.16-ны өдрийн А/50 дугаар тушаалаар нийт 24,074.6 мянган төгрөгийн бараа материал акталж, бараа материалын үлдэгдэл 12,641.5 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан байна.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн хөрөнгөөр 33,902.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 9,971.2 мянган төгрөг, хандиваар 8,000.0 мянган төгрөг нийт үндсэн хөрөнгө тайланд онд 51,873.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын хурлын хуралдааны 2023 оны 12 сарын 05-ны өдрийн 17/66 дугаар тогтоолоор 56,706.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна. Авто тээврийн хэрэгсэл 18,000.0 мянган төгрөгийг балансаас балансt шилжүүлэн данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 43,545.8 мянган төгрөгөөр буурч, 1,315,225.6 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 43,545.8 мянган төгрөгөөр буурч 1,315,225.6 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,077,330.4 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 1,077,330.4 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслөөс 28,886.0 мянган төгрөгөөр буурч 1,048,466.4 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,171,523.1 мянган төгрөг болгож 123,056.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 (Ерөнхий боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 1,171.523.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урьд оны үлдэгдлээс санхүүжих 180,967.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1,193.7 мянга, орон нутгийн санхүүжилтээр 116,655.3 мянган төгрөг нийт 1,470,339.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 1,287,522.7 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 177,491.6 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 116,655.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 95.7 хувь буюу 111,681.9 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 4,973.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/ төгрөгөөр/

| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 3,061,9 | 3,040,7 | 21,2 | 99.30% |

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ 005

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 80312 Сургалт семинар | 1,531,0 | 1,531,0 | 0 | 100% |
| 3 | 81605 Эрүүл мэндийг дэмжих | 3,061,9 | 3,060,0 | 1,9 | 99.90% |
| 4 | 81801 Үдийн цай хөтөлбөр | 75,128,6 | 60,192,0 | 14,936,6 | 80.10% |
| 5 | 81806 Дотуур байрны үйлчилгээ | 51,116,2 | 44,859,0 | 6,257,2 | 87.80% |
| 6 | 81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 32,091,1 | 32,090,7 | 0,35 | 100% |
| 7 | 81823 Боловсролын байгууллагын багш | 6,922,9 | 6,919,2 | 3,7 | 99.90% |
| 8 | **81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр** | 5,635,0 | 4,241,4 | 1,393,5 | 75.30% |
| 9 | 81834 Боловсролын стандарт, сургалтын | 878,773,0 | 761,574,3 | 117,198,7 | 86.70% |
| 10 | 81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 295,309,0 | 257,631,5 | 37,537,4 | 87.3 |
| 11 | 81848 Сурах бичгийн түрээс | 1,053,7 | 705,9 | 347,8 | 67% |
| 12 | 80112 Нийтлэг үйлчилгээ | 116,655,3 | 111,681,8 | 4,973,4 | 95.70% |
| ДҮН | | 1,470,339,6 | 1,287,527,7 | 182,671,9 | |

/

Эх сурвалж:2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд үдийн хоол хөтөлбөрт 75,128.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр Баялаг алтан гандирс ХХК, Чандмань бөмбөгөр ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 60,192.0 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 27,439.4 мянган төгрөг батлагдаж төсөвт 2 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр Хонгор арвай ХХК, Баялаг алтан гандирс ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 25,968.4 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 16,922.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О.Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын нийт зардлын 845,835.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,687.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 9,515.6 мянган төгрөгөөр тогтоосон гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,136,494.3 мянган төгрөгийн 59 гүйлгээг бүрэн мэдээлж, зарлагын 151,015.5 мянган төгрөгийн 19 гүйлгээ мэдээлэхээс 17,664.1 мянган төгрөгийн зарлагын 2 гүйлгээг мэдээлээгүй, 6.4.8-д ”Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл”-д заасан үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоол нийлүүлэх гэрээ, цахим худалдан авалтын гэрээг байршуулаагүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ
005

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 6.4.5-д “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 17,664.1 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, өмч хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой гэрээг бүрэн байршуулах талаар албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б. Нарангэрэл гүйцэтгэж, 6,290.3 мянган төгрөгийн албан шаардлага, 6,701.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 3 | 8290.2 | 3 | 8290.2 | 100 |
| Зөвлөмж | 3 | 6701.9 | 3 | 6701.9 | 100.0 |
| Нийт дүн | 6 | 14,992.1 | 6 | 14,992.1 | 100.0 |

*Эх сурвалж: Бөмбөгөрсумын ерөнхий боловсролын сургуулийн 2023.05.18-ны өдрийн 46 дугаар албан бичиг*

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.31-ий өдөр 46 дугаар албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 21,103.6 мянган төгрөгийн 4 зөрчил[1] илэрсэнд 2 төлбөрийн акт, 1 зөвлөмж, нийцлэлийн аудитын холбоотой 17,664.1 мянган төгрөгийн 1 албан шаардлага өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1.Илрүүлэлт: Улирлын ажлын үр дүнгээр төрийн үйлчилгээний ажилчдад мөнгөн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт"Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох" журмын 4.8 дахь заалтыг зөрчин урамшуулал олгох хувийг зөрүүтэй тооцон 2,217.6 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт"Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох" журмын 4.8 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
Шийдвэрлэсэн нь: Илүү тооцон олгосон 2.217,6 мянган төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогчоор төлүүлэх төлбөрийн акт тогтоов.
2. Илрүүлэлт: Цахим хэрэглээний зардлаас 1,386.0 мянган төгрөгийн багшаас бусад ажилтанд олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар 2.4 дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний зардлыг нийт үндсэн багш,бүлгийн болон хөгжим биеийн тамирын багшийн нийт тоогоор тооцно. гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 1,386.0 мянган /Нэг сая гурван зуун наян зургаан мянга/ төгрөгийг холбогдох төсвийн захирагчаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 6.4.5-д "Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ"-д заасан 17,664.1 мянган төгрөгийн орлогын 2 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой гэрээг бүрэн байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлнэ гэсэн заалтыг зөрчсөн тул зөрчлийн арилгах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

1. Хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт Бөмбөгөр сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 15/10 дугаар тогтоолоор сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сургууль орчны тохижилт 20,000.0 мянган төгрөгөөр төгрөгийн үндсэн хөрөнгөнд авах тогтоолыг хэрэгжүүлээгүй, 17,500.0 мянган төгрөгийг нийтийн байгууламжийн ангилалд бүртгээгүй хөрөнгийг аж ахуйн материалын дансанд орлого авсан.

Энэ нь УСНББОУС -16,18 стандартыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө орлогыг УСНББОУС-16,18 стандартын дагуу ангиллын дагуу орлогод авч тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 оны 03 сарын 25-ны дотор зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Улирлын ажлын үр дүнгээр төрийн үйлчилгээний ажилчдад мөнгөн урамшуулал олгохдоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт"Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох" журмын 4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй урамшуулал олгох хувийг зөрүүтэй тооцон 2,217.6 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон. | 1 | 2,217.6 | 1 | 2,217.6 | | | 0 | 0 |
| Цахим хэрэглээний зардлаас1386.0 мянган төгрөгийн багшаас бусад ажилтанд олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. | 1 | 1,386.0 | 1 | 1,386.0 | | | 0 | 0 |
| Бөмбөгөр сумын ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 15/10 дугаар тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр сургууль орчны тохижилт 20.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөнд авах тогтоолыг хэрэгжүүлээгүй, 17.5 сая төгрөгийн нийтийн байгууламжийн ангилалд бүртгэх хөрөнгийг аж ахуйн материалын дансанд орлого авсан | 1 | 17,500.0 | | | | | 1 | 17,500.0 |
| Нийт дүн | 1 | 21,103.6 | | 3,603.6 | | | 1 | 17,500.0 |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17664.1 мянган төгрөгийн гүйлгээний мэдээллийг байршуулаагүй , төсөв хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэрийг байршуулаагүй | 1 | 17,664.1 | | | 1 | 17,664.1 | | |
| Дүн | 1 | 17,664.1 | 0 | 0 | 1 | 17,664.1 | 0 | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo---

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ 005

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 58/14210513/2024 195/НА-СТА-ПІ/24З Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахим хэрэглээний зардлаас багшаас бусад ажилтанд 1,386,000.0 төгрөгийн дата эрх өгч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/170 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар 2.4 дата багцыг сонгосон нөхцөлд цахим хэрэглээний зардлыг нийт үндсэн багш,бүлгийн болон хөгжим биеийн тамирын багшийн нийт тоогоор тооцно. гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар зарцуулсан 1,386,000 /Нэг сая гурван зуун наян зургаан мянга / төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.
1. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар

5050117

сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Гантөмөр, нягтлан бодогч Б.Ганболд нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр Дугаар 62/1421057З/БНА/2024 /95/НА-СТА-ТУЗ Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улирлын ажлын үр дүнгээр төрийн үйлчилгээний ажилтдад мөнгөн урамшуулал олгох хувийг зөрүүтэй тооцон 2,217,675 төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт"Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох" журмын 4.8 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь "Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан " гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Урамшуулалд илүү олгосон 2,217,675 /Хоёр сая хоёр зуун арван долоон мянга зургаан зуун далан таван/ төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2.Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05

5050129

дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Гантөмөр, нягтлан бодогч Б.Ганболд нарт хариуцуулав[1].

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН[2]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

[1] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[2] Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 2 сарын 23 өдөр Дугаар 103/142105131/ФИА/2024 /95/ИА-СТА-ТШЗ. Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 17,664,100 төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй зөрчил гарсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй, мөн санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх[1].

---

[1] Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

5040203

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Бөмбөгөр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Гантөмөр, нягтлан бодогч Б.Ганболд нарт даалгав[2].

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН[3]:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН
АУДИТОР: О.МАНДАХ

[2] Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

[3] Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно